



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 451

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4.1.5 дахь заалтыг тус тус хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1. Эрчим хүчний сайдын 2018 оны а/3683 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Бямба-Очирыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

1.2 Эрчим хүчний сайдын 2018 оны а/3683 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 05/8810 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Ч.Саранжавыг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА